



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/36

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” Төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэхь хэсэг 4.2.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 5 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2019 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн
А/36 дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах
арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны компаниуд**

1. "Алтан Хоромсог ҮЦК" ХХК
2. "Блэкстоун Интернэйшнл ҮЦК" ХХК
3. "Дэлгэрхангай Секюритиз ҮЦК" ХХК
4. "Евразиа Капитал Холдинг ҮЦК" ХК
5. "Монгол Секюритиес ҮЦК" ХК

---oOo---